



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/45

Өвт

Цэцэрлэгүүдийн сургалтын үйл
ажиллагааг түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 482 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж”-ийн 6.2, 8.2.1 дэх хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 03 дугаар сарын 3 дахь 7 хоногийн томуу, томуу төст өвчний мэдээлэл судалгаагаар нийт өвчлөлийн 63,3 хувийн бага насны хүүхдүүд эзэлж байгаа тул 2022 оны 03 дугаар сарын 29-өөс 04 дүгээр сарын 10-ны өдрийг дуусталх хугацаанд 1, 2 дугаар Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг түр зогсоосугай.

2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж, хүүхдүүдэд зайны болон цахим сургалтаар сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч (Н.Батжаргал), 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Ж.Тогоохүү) нарт даалгасугай.

3. Томуу, томуу төст өвчний хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаагаа сайжруулах чиглэлээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, үр дүнтэй ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүрэг гүйцэтгэгч (Х.Цэдэндорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



622,01088

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/